



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ  
ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА**

**MNS 6392 : 2013**

**Албан хэвлэл**

Улаанбаатар  
2014 он



**МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ**

---

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ  
ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА**

**MNS 6392 : 2013**

**Албан хэвлэл**

Улаанбаатар  
2014 он

*Стандартчилал, хэмжил зүйн газрын зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яам  
1500 хувийг хэвлэв. 2014 он*

## ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ ЭРҮҮЛ АХУЙН ШААРДЛАГА

Уг стандартыг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 42 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулав.

Боловсруулсан:

Ш.Уранцэцэг, ЭМЯ-ны Орчны эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн  
Л.Оюунтогос, ДЭМБ-ийн мэргэжилтэн  
Л.Баярцэцэг, Улсын III төв эмнэлгийн Стратеги төлөвлөлт эрхлэсэн орлогч дарга  
Д.Баярболд, МХЕГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга  
Б.Баясгалан, МХЕГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч  
Д.Батдулам, МХЕГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч  
Г.Батмөнх, НМХГ-ын Эрүүл мэнд, соёлын хяналтын хэлтсийн дарга  
Т.Отгон, НМХГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч  
Б.Золбоо, НМХГ-ын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч  
С.Цэгмид, НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээн ажилтан  
М.Оюунчимэг, НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан  
А.Энхтуяа, ЭМБЗӨДҮ ТББ-ын гишүүн

Энэхүү стандартыг Эрүүл мэндийн яамны ажлын хэсэг боловсруулж, Стандартчилал, хэмжилзүйн газрын дэргэдэх Эрүүл мэндийн стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцэн дэмжиж Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар батлав.

Уг стандартыг Монгол хэлнээс Англи хэл рүү орчуулан, хэвлүүлэх ажлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр гүйцэтгэв.

Англи хэл рүү орчуулсан:

Д.Нарансүх, АШУҮИС-ийн НЭМС-ийн багш

Орчуулгыг хянасан:

С.Төгсдэлгэр, ЭМЯ –ны Хяналт-Шинжилгээ, Үнэлгээ, Дотоод аудитын газрын дарга

## ӨМНӨХ ҮГ

Сүүлийн жилүүдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүрээ өргөжиж, эмчилгээ, оношлогооны чадавхи сайжирч байгаа хэдий ч эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах, эдэлбэр газар, орчны тохижилт, ундны усны чанар, аюулгүй байдал, ариун цэврийн байгууламж, хатуу, шингэн хог хаягдлыг менежмент нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй байх дутагдлууд түгээмэл илэрч байна.

Эмнэлгийн байгууллагуудад нийтлэг илэрч байгаа дээрх дутагдалууд нь нэг талаас эмнэлгийн байгууллагуудын үүрэг хариуцлага сул, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо муу, нөгөө талаас эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйтэй холбоотой байна.

2013 оны байдлаар Монгол улсад эрүүл мэндийн байгууллага, эмчилгээ, оношлогооны үйл ажиллагааг холбоотой 1105 стандарт байна. Эдгээрээс 546 нь эм зүй, 403 нь оношлогоо эмчилгээний нийтлэг асуудал, 12 нь эрүүл мэндийн байгууллагын бүтэц үйл ажиллагаа, 156 нь бусад чиглэлийн стандартууд байв. Уг стандартууд нь эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, үйл ажиллагаа, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байна. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйд тавигдах шаардлагын талаар стандарт байсангүй.

Иймээс эрүүл мэндийн байгууллагуудын орчны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулахад энэхүү стандартыг зайлшгүй боловсруулан, мөрдүүлэх шаардлагатай юм. Энэхүү стандартыг боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2013 оны 42 тоот тушаалаар байгуулагдсан бөгөөд ЭМЯ, ДЭМБ, МХЕГ, НМХГ, НЭМҮТ, УКГЭ, “Эрүүл мэндийн байгууллагуудад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх” ТББ байгууллагуудын төлөөллөөс бүрдэв.

Стандартыг боловсруулахад ДЭМБ-ийн зөвлөмж “Essential environmental health standards in health care, WHO, 2008”, ОХУ-ын эрүүл мэндийн байгууллагад тавих эрүүл ахуйн шаардлага дүрэм “СанПин2.1.3.1375-03, Гигиенические требования к размещению, устройству, оборудованию и эксплуатации больниц, родильных домов и других лечебных стационаров, 2007” бичиг баримтыг үндсэн лавлагаа болгон ашиглав. Стандартын төслийг холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд танилцуулан хэлэлцүүлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэв.

“Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 стандарт батлагдснаар эмнэлгийн байгууллагын ус, ариун цэвэр эрүүл ахуй, эмнэлгийн хог хаягдал, эмнэлгийн халдвар хамгаалал, хүнсний аюулгүй байдал, дотоод орчны агааржуулалт, гэрэлтүүлэг, эдэлбэр газар, зүлэгжүүлэлт зэрэг олон асуудал шийдвэрлэгдэх ялангуяа эмнэлгийн газар олголт, зураг төслийн үе шатнаас эхлэн дээрхи асуудлуудыг цогцоор шийдвэрлэгдэх боломж нөхцөл бүрдэж байна.

Стандартыг боловсруулах, Монгол хэлнээс Англи хэл рүү орчуулах ажлыг гүйцэтгэхэд арга зүйн болон санхүүгийн туслалцаа дэмжлэг үзүүлсэн ДЭМБ-д гүн талархал илэрхийлье.

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

*Стандартчилал, хэмжил зүйн газрын зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яам  
1500 хувийг хэвлэв. 2014 он*

## Агуулга

Өмнөх үг .....	6
1 Зорилго.....	8
2 Хамрах ба хэрэглэх хүрээ .....	8
3 Норматив эшлэл.....	8
4 Барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага.....	10
5 Усны чанар, аюулгүй байдал.....	25
6 Шингэн хог хаягдлын зайлуулалт .....	26
7 Угаалга, цэвэрлэгээ.....	27
8 Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал .....	30
9 Хог хаягдал.....	31
10 Шавьж мэрэгчээр дамжих өвчний хяналт .....	31
11 Эрүүл ахуйг дэмжих, сургалт мэдээллийн үйл ажиллагаа .....	302

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 11.020

Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага. MNS 6392 : 2013	Environmental hygienic requirements for health facilities. MNS 6392 : 2013
--	---

Стандартчиллынүндэсний зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн34 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй болно. Энэхүү стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

<b>1 Зорилго</b>	<b>1 Objective</b>
Энэхүү стандартын зорилго нь зориулалтын байранд чанартай, аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд оршино.	The objective of this standard is to ensure the provision of quality and safe health services in custom-built facilities.
<b>2 Хамрах ба хэрэглэх хүрээ</b>	<b>2 Scope</b>
<b>2.1</b> Энэхүү стандартад эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, гадаад болон дотоод орчны эрүүл ахуйн нөхцөл, халдвар хамгааллын дэглэмд тавих шаардлага хамаарна.	<b>2.1</b> The standard sets requirements for hygienic conditions and infection control regimen in buildings and structures, and outdoor and indoor environment of health facilities.
<b>2.2</b> Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн газар сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөх, ашиглалтад оруулахад мөрдөнө.	<b>2.2</b> The standard is to be followed in selecting a construction site and developing an architectural plan for building or expanding health facilities.
<b>2.3</b> Энэхүү стандартыг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, үнэлгээ хийх, магадлан итгэмжлэх, хяналт тавихад хэрэглэнэ.	<b>2.3</b> The standard is to be utilized for evaluating, accrediting and inspecting public and private health facilities.
<b>3 Норматив эшлэл</b>	<b>3 Normative reference</b>
Энэ стандартад ишлэл хийсэн дараах стандарт, баримт бичиг, тэдгээрт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлээс эш татаж хэрэглэнэ.	The following referenced documents are indispensable for the application of this document. For undated references, the latest edition of the referenced document (including any amendments) applies.
<ul style="list-style-type: none"><li>- MNS 6330-1:2012, Төв эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт</li><li>- MNS 6330-2:2012,Тусгай мэргэжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа</li><li>- MNS 6330-3:2012,Тусгай мэргэжлийн оргүй төвийн бүтэц, үйл ажиллагаа</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- MNS 6330-1:2012, Structure and Performance of Central Hospital</li><li>- MNS 6330-2:2012, Structure and Performance of Specialized Medical Center</li></ul>

Стандартчилал, хэмжил зүйн газрын зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яам  
1500 хувийг хэвлэв. 2014 он

- MNS 6330-4:2012, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 5292:2011, Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа
- MNS 5095:2001, Аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт
- MNS 5232 : 2003, Рашаан сувиллын бүтэц, үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага
- MNS 5082:2001, Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага
- MNS 6188-3:2010, Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа
- MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлт. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ
- MNS 12.1.009:1985, Хөдөлмөр хамгаалал. Шуугиан. Орон сууц, иргэний барилгын шуугианы байж болох түвшин
- MNS 0900:2010, Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Түүнд тавих хяналт
- БНБД 30.01.03, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм
- Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41.01.11
- MNS 4943:2011, “Усны чанар. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
- MNS 5924:2008, Нүхэн жорлон. Угаадасны нүх.Техникийн шаардлага
- СанПин 2.1.3.1375-03, Санитарно-эпидемиологические правила и нормативы, 2007, Гигиенические требования к размещению, устройству, оборудованию и эксплуатации больниц, родильных домов и других лечебных стационаров.
- MNS 6055:2009, Иргэний барилга төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин
- БД 31-115-11, Эмнэлгийн барилга
- Цацрагийн аюулгүйн норм. ЦАН-83
- MNS 6330-3:2012, Structure and Performance of Specialized Outpatient Medical Center
- MNS6330-4:2012, Structure and Performance of Regional Diagnostic and Treatment Center
- MNS 5292-3:2011, Structure and Performance of Family Health Center
- MNS 5095-3:2001, Structure and Performance of Aimag General Hospital
- MNS 5232:2003, Structure and Performance of Spa and Resorts. General Requirements
- MNS 5082:2001, Structure and Performance of Soum Hospital. General Requirements
- MNS 6188-3:2010, Maternity Hospital Structure and Performance
- MNS 5161-3:2002, Pest Control, Deratization and Disinfection. Part Three. Services
- MNS 12.1.009:1985, Occupational Safety. Noise. Threshold Limits for Noise in Housing and Civil Engineering
- MNS 0900:2010, Potable Water. Hygienic Requirements. Its Inspection
- Construction Norms and Rules 30.01.03, Norms and Rules of Urban Planning and Construction
- Construction Norms and Rules 41.01.11, Heating, Air Exchange and Conditioning
- MNS 4943:2011, Water Quality. Environmental Release of Treated Wastewater. General Requirements
- MNS 5924:2008, Pit Latrine. Wastewater Pit. Technical Requirements
- Hygienic Rules and Norms 2.1.3.1375-03, 2007, Hygienic Requirements for Construction Site Selection, Civil Works, Furnishing and Exploitation of Hospitals, Maternity Hospitals and Other Inpatient Facilities
- MNS 6055:2009, Special Considerations in Planning Space and Environment for the Disabled in Civil Works
- Construction Rule 31-115-11, Hospital Building
- Radiation Safety Norm–83, Radiation Safety Norm

#### 4 Барилга байгууламжид тавих эрүүл ахуйн шаардлага

##### 4.1 Барилга байгууламжийн гадна орчны шаардлага

**4.1.1** Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийг гэр хорооллоос 100 метр, үйлдвэрийн барилга байгууламжаас 1000 метр алслагдсан зайд барихаар төлөвлөнө.

**4.1.2** Халдварт, сүрьеэ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийг хүн амын суурьшлын бүсийн гадна байхаар төлөвлөнө.

**4.1.3** Эрүүл мэндийн байгууллагын эдэлбэр газрын хэмжээг орны тоо болон үйлчилгээний хүчин чадлаас хамаарч 1-р хүснэгтийн дагуу тооцно.

#### 4 Hygienic requirements for buildings

##### 4.1 Requirements for outdoor environment

**4.1.1** Health facilities should be located at least 100 meters distant from residential districts and at least 1000 meters distant from industrial facilities.

**4.1.2** Health facilities for communicable diseases, tuberculosis or psychiatric patients should be located outside residential area.

**4.1.3** Land area of a health facility shall be determined depending on the number of hospital beds and its service capacity as per Table 1 and 2.

#### 1-р хүснэгт-Эрүүл мэндийн байгууллагын эдэлбэр газрын хэмжээ

№	Орны тоо	Нэг оронд ногдох талбайн хэмжээ /м <sup>2</sup>
1	50 хүртэл ортой	300
2	50-100 ортой	300-200
3	100-200 ортой	200-140
4	200-400 ортой	140-100
5	400-800 ортой	100-80
6	800-аас дээш ортой	60

#### Land Area of a Health Facility

№	Number of hospital beds	Land area per hospital bed (sq.m)
1	Less than 50	300
2	50-100	300-200
3	100-200	200-140
4	200-400	140-100
5	400-800	100-80
6	More than 800	60

#### 2-р хүснэгт-Поликлиникийн эдэлбэр газрын хэмжээ

№	Поликлиникийн хүчин чадал	Эдэлбэр газрын талбайн хэмжээ, /м <sup>2</sup>
1	Нэг ээлжинд 100 хүн үзэх поликлиник	2500
2	Нэг ээлжинд 150-200 хүн үзэх поликлиник	3500
3	Нэг ээлжинд 400 хүн үзэх поликлиник	4500

ТАЙЛБАР: Эдэлбэр газрын талбайн хэмжээг хүүхдийн эмнэлэгт 1,5; амаржих газарт 0,7 итгэлцүүрээр үржүүлэн төлөвлөнө. Эрүүл мэндийн байгууллагын эдэлбэр газрыг хүн амын суурьшлын бүсийн гадна халдварт, хавдар судлалын эмнэлэгт 15 %-иар, сүрьеэ, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт 25 %-иар, насанд хүрэгчдийн нөхөн сэргээх сувилалд 20 %-иар, хүүхдийн нөхөн сэргээх сувилалд 40 %-иар нэмэгдүүлэн төлөвлөж болно. Хүн амын суурьшлын бүс доторхи эмнэлгийн эдэлбэр газрыг төлөвлөхдөө 25 % хүртэл бууруулж болно.



## Land Area of an Outpatient Facility

№	Service capacity	Land area per hospital bed (sq.m)
1	100 clients per shift	2500
2	150-200 clients per shift	3500
3	400 clients per shift	4500

NOTES: For calculation of land area of a pediatric and maternity hospital correction factor of 1.5 and 0.7 should be used, respectively. Land area of health facilities outside residential area could be increased as follows: communicable disease and oncology facilities – by 15%, tuberculosis and psychiatric facilities – by 25%, adult rehabilitation center – 20%, child rehabilitation center – 40%. Land area of health facilities within residential area could be decreased by up to 25%.

**4.1.4** Эрүүл мэндийн байгууллагын эдэлбэр газрын талбайн 60-аас доошгүй хувь нь ногоон байгууламжтай байна.

**4.1.5** Эрүүл мэндийн байгууллагын эдэлбэр газрын талбайн хэмжээгээр хүрээлсэн хашаатай, явган хүн болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй үйлчлүүлэгчдэд зориулсан цардмал зам төлөвлөнө.

**4.1.6** Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны гэрэлтүүлэг бүрэн, хүрэлцээтэй, галын аюулаас сэргийлсэн бүрхүүлтэй байна.

**4.1.7** Ажилчид болон үйлчлүүлэгчдийн машины зогсоолын талбайг тохижуулан байршлын тэмдэг тавина.

**4.1.8** Тээврийн хэрэгслийн зогсоолын талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээ хийнэ.

### 4.2 Барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага

**4.2.1** Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж нь зориулалтын зураг төслийн дагуу баригдсан байна.

**4.2.2** Барилга нь 8-10 баллын газар хөдлөлтөнд тэсвэртэй, аянга зайлуулагч газардуулгатай байна.

**4.2.3** Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийг 9 давхар хүртэл төлөвлөх ба 3 хүртэлх насны сахиуртай хүүхдийн тасгийг 5 хүртэлх давхарт, 7 хүртэлх насны болон сэтгэцийн эрүүл мэндийн өвчтэй хүүхдийг эмчлэх тасгийг 2-оос доош давхарт байрлуулна.

**4.1.4** Plantation shall occupy at least 60 percent of land area of a health facility.

**4.1.5** Land area of a health facility shall be fenced, and walking trails for pedestrians, the elderly and the disabled shall be paved.

**4.1.6** Outdoor lights shall be placed in sufficient numbers, be in working order, and have fire-proof covers.

**4.1.7** Parking lot for employees and customers shall be constructed and clearly marked.

**4.1.8** Dedicated disabled parking spaces shall be clearly marked and reserved for people with disabilities.

### 4.2 Hygienic requirements for buildings

**4.2.1** Health facility buildings shall be constructed in accordance with an architectural plan.

**4.2.2** Health facility buildings shall be resistant to 8-10 magnitude earthquakes, be properly earthed and have lightning shields.

**4.2.3** Health facility buildings shall have up to 9 storeys. Pediatric wards for children under 3 years of age with custodians shall be located up to the 5<sup>th</sup> storey, and wards for children under the age of 7 years and underage psychiatric patients shall be located up to the 2<sup>nd</sup> storey.

**4.2.4** Patient rooms shall be 3.3 meters in height, and operating theaters shall be 3.5-5.4 meters in height.

**4.2.4** Үйлчлүүлэгчийн өрөөний өндөр 3,3 метр, мэс заслын өрөөний өндөр 3,5-5,4 метр байна.

**4.2.5** Нэг ортой үйлчлүүлэгчийн өрөөний өргөн 3 метрээс багагүй, үйлчлүүлэгчийн тасгийн хонгилын өргөн 2,4 метр, мэс заслын болон эрчимт эмчилгээний тасгийн хонгилын өргөн 2,8 метр өргөнтэй байна.

**4.2.6** Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, халдварын эсрэг дэглэмийг мөрдөж, өрөөний талбайн хэмжээг 3-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

**4.2.5** Single occupancy patient rooms shall be no less than 3 meters in width, corridors of regular wards shall be 2.4 meters in width, and corridors of surgical and intensive care units shall be 2.8 meters in width.

**4.2.6** Area of patient rooms shall be planned to ensure patient safety and infection control regimen, and in accordance with Table 3.

**3-р хүснэгт-Үйлчлүүлэгчийн өрөөний талбайн хэмжээ**

№	Өрөөний нэр	1 оронд ноогдох талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	
1	Халдвартын болон сүрьеэгийн тасгийн насанд хүрэгчдийн 1 оронд	8	
2	Халдвартын болон сүрьеэгийн тасгийн хүүхдийн 1 оронд	Хүүхдийн өрөө	6,5
		өдрийн цагаар сахиуртай байх хүүхдийн өрөө	8,0
		Сахиуртай хүүхдийн өрөө /24 цагийн турш/	10,0
3	Гэмтлийн тасгийн 1 оронд	Насанд хүрэгсдийн болон өдрийн цагаар сахиуртай байх хүүхдийн өрөө	10,0
		Сахиуртай хүүхдийн өрөө /24 цагийн турш/	13,0
4	Мэс заслын дараах болон эрчимт эмчилгээний өрөө	13,0	
5	Хүүхдийн тасгийн 1 оронд ноогдох талбай	Хүүхдийн өрөө	6,0
		өдрийн цагаар сахиуртай байх хүүхдийн өрөө	7,5
		Сахиуртай хүүхдийн өрөө /24 цагийн турш/	9,5
6	Сэтгэц, мэдрэлийн ба наркологийн эмнэлэгийн 1 оронд ноогдох талбай	Үйлчлүүлэгчийн өрөө	6,0
		Инсулин ба наркологийн өрөө	7,0
7	Сэтгэцийн өвчтэй хүүхдийн тасгийн 1 оронд ноогдох талбай	Ердийн	6,0
		Хяналтын	7,0
8	Төрсөн нярайн тасгийн 1 оронд ноогдох талбай	6,0	
9	2 ба түүнээс дээш ортой үйлчлүүлэгчийн өрөөний 1 оронд ноогдох талбай	7,0	
10	1 ортой үйлчлүүлэгчийн өрөөний 1 оронд ноогдох талбай	9,0	
11	Халдвартын эмнэлгийн 1 ортой хагас боксын өрөө	12-14 м <sup>2</sup>	
12	1 ортой бүтэн боксын өрөөний талбай	20-22 м <sup>2</sup>	

## Patient Room Area

№	Room Type	Area per hospital bed (sq.m)	
1	Communicable disease and tuberculosis ward rooms for adults	8,0	
2	Communicable disease and tuberculosis ward rooms for pediatric cases	Children without custodians	6,5
		Children with day-time custodians	8,0
		Children with custodians (24 h)	10,0
3	Traumatology ward rooms	For adults or children with day-time custodians	10,0
		Children with custodians (24 h)	13,0
4	Post-surgical and intensive care unit rooms	13,0	
5	Pediatric ward rooms	Children without custodians	6,0
		Children with day-time custodians	7,5
		Children with custodians (24 h)	9,5
6	Psychiatric, neurology and narcology ward rooms	Patient room	6,0
		Insulin treatment and detox rooms	7,0
7	Pediatric psychiatric ward rooms	Regular room	6,0
		Observation room	7,0
8	Newborn unit rooms	6,0	
9	Patient rooms with 2 or more hospital beds	7,0	
10	Single occupancy patient rooms	9,0	
11	Single occupancy semi-isolation rooms for patients with communicable diseases	12-14	
12	Single occupancy full-isolation rooms for patients with communicable diseases	20-22	

**4.2.7** Эмчилгээ оношилгоо, лаборатори, эмгэг судлал, ариутгал, угаалга, гал тогоо зэрэг бусад өрөөний талбайн хэмжээг норматив ишлэлд дурьдсан стандартын дагуу төлөвлөнө.

**4.2.8** Халдвартын эмнэлгийг бүтэн ба хагас боксын өрөөтэй байхаар төлөвлөнө. Бүтэн боксын өрөө нь гаднаас орох тусдаа хаалгатай, бие засах, усанд орох өрөөтэй, хагас бокс нь хоёр өрөөний дунд бие засах, усанд орох өрөөтэй байна.

**4.2.9** Халдвартын эмнэлгийн хүлээн авах тасагт тусгаарлах өрөөг орны тооноос хамааруулан төлөвлөнө. 60 ортой эмнэлэгт 2, 61-100 ортой бол 3, 101-аас дээш ортой бол нийт орны 3 % нь тусгаарлах өрөөтэй байна. Тусгаарлах өрөө нь гадагшаа гарсан хаалга бүхий нэг чигийн урсгалтай, ариун цэврийн өрөө төлөвлөнө.

**4.2.10** Рентген кабинет, ионжсон цацрагаар эмчлэх өрөө, радиоизотопын /цөмийн/

**4.2.7** Space requirements for examination and procedure rooms, and other facilities including laboratory, pathology, sterilization, laundry and kitchen shall be planned in accordance with corresponding Normative References.

**4.2.8** Communicable disease hospitals shall have full and semi-isolation rooms. Full isolation rooms shall have individual doors and sanitary amenities. Semi-isolation rooms shall have sanitary amenities shared between two rooms.

**4.2.9** The number of isolation rooms in admission ward of a communicable disease hospital shall be planned in accordance with the number of its hospital beds. There shall be 2 isolation rooms per 60 hospital beds, 3 isolation rooms per 61-100 hospital beds, and in hospitals with more than 101 beds the number of isolation rooms shall be equal to 3 percent of beds. Isolation rooms shall have individual doors facing outdoors, one-way flow and individual sanitary amenities.

оношилгооны лабораторийн өрөөг төрөх болон хүүхдийн тасагтай зэрэгцээ буюу дээд, доод давхарт нь байрлуулахгүйбөгөөд цацрагийн аюулгүйн нормд заасны дагуу цацрагаар оношлох, эмчлэх өрөө тасалгаанд туяаны хамгаалалт хийнэ.

**4.2.11** Эмнэлгийн барилгын тусгаарлагдсан хэсэгт хагалгааны хэсэг байрлах ба эмчилгээ, оношилгооны бусад тасагтай холбогдохоор төлөвлөнө.

**4.2.12** Мэс заслын өмнөх, гемодиализ, үзлэгийн өрөө, үйлчлүүлэгчийн тасаг болон лаборатори, ариутгал, гал тогоо, угаалга, усанд орох болон бие засах газар зэрэгт мэдрэгчтэй гар угаагуур төлөвлөнө.

**4.2.13** Эрүүл мэндийн байгууллагуудын ариун цэврийн өрөөг 1 суултуурт 1,1x1,6 метр зай хэмжээтэй, хаалга нь гадагшаа онгойхоор төлөвлөх ба мэдрэгчтэй гар угаагууртай байна. Үйлчлүүлэгчийн өрөөнд ариун цэврийн өрөө төлөвлөөгүй тохиолдолд 10 эрэгтэй үйлчлүүлэгчдэд 1 суултуур, 1 шээлтүүр, 8 эмэгтэй үйлчлүүлэгчдэд нэг суултуур бүхий ариун цэврийн өрөө байхаар төлөвлөнө.

**4.2.14** Амбулаториар үйлчлүүлэгчдэд зориулсан ариун цэврийн өрөөг давхар бүрт төлөвлөх ба эмч, эмнэлгийн ажилтнуудын ариун цэврийн өрөөг тусад нь төлөвлөнө.

**4.2.15** 40 үйлчлүүлэгчдэд 1-ээс доошгүй шүршүүр байхаар төлөвлөнө. Халдвартын ба сүрьеэгийн эмнэлгийн ажилчдад 10 хүн тутамд нэг, бусад эмнэлгийн 15 ажилчдад 1-ээс багагүй шүршүүр байхаар төлөвлөнө.

**4.2.16** Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээний өрөөнд хүчилтөрөгчийн аппарат хэрэгсэл холбох шугам хоолойг зураг төслийн дагуу төлөвлөх ба даралттай хийн баллоныг тусдаа өрөөнд байрлуулна.

**4.2.17** Эмнэлэг нь стандартын шаардлага хангасан агуулах, архив, сургалтын зориулалтын өрөөтэй байна.

**4.2.18** Эмнэлгийн барилга байгууламжид зориулалтын цахилгаан шат төлөвлөнө.

**4.2.10** X-ray cabinets, ionized radiation treatment rooms and radiology (nuclear) diagnostic rooms shall not be located adjacent to, directly below or directly above delivery or pediatric wards. Radiology rooms shall have radiation protection in compliance with radiation safety norms.

**4.2.11** Operation theatre shall be located in an isolated wing of the hospital building, and shall have connections to other treatment and diagnostic wards.

**4.2.12** Operation theatre, hemodialysis and examination rooms, patient wards, laboratory, sterilization, kitchen, laundry and sanitary amenities shall have washbasins with sensors.

**4.2.13** Sanitary amenities in health facilities shall have floor area of 1.1 x 1.6 meters per lavatory pan, outwards facing doors and washbasins with sensors. In case of communal sanitary facilities there shall be 1 flush toilet and 1 urinal per 10 male patients, and 1 flush toilet per 8 female patients.

**4.2.14** Sanitary amenities for outpatients shall be located on every floor, and staff shall have separate amenities.

**4.2.15** There shall be at least 1 shower per 40 patients. There shall be at least 1 shower per 10 staff of communicable disease and tuberculosis hospitals, and 1 shower per 15 staff in other hospitals.

**4.2.16** Medical piped gas systems for reanimation and intensive care units shall be planned in accordance with technical drawings, and compressed gas cylinders shall be located in a separate room.

**4.2.17** Health facility shall have proper stockrooms, archives and training rooms.

**4.2.18** Health facility shall have proper elevators

### **4.3 Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны эрүүл ахуйн шаардлага**

**4.3.1** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд холбогдох стандартын дагуу ээлтэй орчинбүрдүүлж ажиллана.

**4.3.2** Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөөг 6 м<sup>2</sup>-аас багагүй талбайтай, хана дагасанбариултай байхаар төлөвлөнө.

### **4.4 Агааржуулалт**

**4.4.1** Эрүүл мэндийн байгууллагын өрөө тасалгааны бичил цаг уурын хэвийн нөхцлийг хангах зорилгоор энгийн болон агааржуулалтын механик төхөөрөмжтэй байна.

**4.4.2** Эрүүл мэндийн байгууллагын өрөө тасалгааны хэм, агаар солилцооны давтамж, цэврийн зэрэглэлийг 4-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

### **4.3 Hygienic requirements for health facility environment: specific provisions for the elderly and the disabled.**

**4.3.1** Health facility shall have friendly environment for the disabled in compliance with relevant standards.

**4.3.2** Sanitary amenities for the elderly and the disabled shall have a floor area equal to or more than 6 sq.m, and have handrails along the walls.

### **4.4 Ventilation**

**4.4.1** Health facility rooms shall be equipped with conventional or mechanical ventilation system in order to meet proper microclimate requirements.

**4.4.2** Room temperature, the frequency of air exchange and the degree of room cleanliness shall be planned in accordance with the requirements spelled out in Table 4.

**4-р хүснэгт-Эрүүл мэндийн байгууллагын өрөө тасалгааны температур,  
агаар солилцооны давтамж**

№	Өрөөний нэр	Өрөөний хэм °C	1 цагийн агаар солилцооны давтамж		Өрөө, тасалгааны цэврийн зэрэг	Энгийн агааржуулалт хийх давтамж
			Өгөх	Сорох		
1	Насанд хурэгчдийн болон сахиуртай хүүхдийн өрөө	20	1 оронд 80 м <sup>3</sup> /цаг 100 %		Цэвэр	2
2	Сүрьеэгийн өвчний өрөө	20	1 оронд 80 м <sup>3</sup> /цаг 80 %      100 %		Бохир	2
3	Гипогиреозтой өвчний өрөө	24	1 оронд 80 м <sup>3</sup> /цаг 100 %		Цэвэр	2
4	Тиреотоксикозтой өвчний өрөө	15	1 оронд 80 м <sup>3</sup> /цаг 100 %		Цэвэр	2
5	Мэс заслын, мэс заслын дараах, эрчимт эмчилгээ, нойрсуулах, төрөх өрөө, 1-2 ортой түлэгдэлттэй өвчний болон барокамерын өрөө	22	Тооцоогоор*, гэхдээ 10-аас багагүй удаа агаарын солилцоо хийнэ		Цэвэр	Төлөвлөх шаардлага-гүй
6	Төрсний дараах өрөө	22	100 %*	100%	Цэвэр	Төлөвлөх шаардлагагүй
7	Хүүхдийн болон 2-4 ортой түлэгдэлттэй өвчний өрөө	22	100 %	100%	Цэвэр	Төлөвлөх шаардлагагүй
8	Нярай, дутуу төрсөн, хөхүүл, гэмтэлтэй хүүхдийн өрөө	25	Тооцоогоор 100 %*      80% 100 %*      100%		Цэвэр	Төлөвлөх шаардлага-гүй
9	Бүтэн ба хагас бокс, боксын өмнөх өрөө	22	2,5 (хонгилоос өгөх агаар 100 %)	2,5	Бохир	2,5
10	Халдвартын эмнэлгийн өвчний өрөө	20	1 оронд 80 м <sup>3</sup> /цаг 100 %		Бохир	-
11	Төрөхийн өмнөх, хүлээн авах, үзлэгийн, боолтын, гардан үйлдэл, мэс заслын өмнөх, 1 нас хүртэлх хүүхдийн өрөө	22	2	2	Цэвэр	2
12	Ариутгалын өрөө	18	-	3	Бохир Цэвэр	2
13	Жижиг мэс ажилбарын өрөө	22	10	5	Цэвэр	1
14	Эмч, ажилчдын өрөө	20	Хонги лоос агаар орно	1	Цэвэр	1
15	Үйл ажиллагааны оношилгооны өрөө	22	-	3	Бохир	2
16	Физик эмчилгээний өрөөнүүд	20	2	3	Бохир	2
17	Физик эмчилгээ /шарлага, халуун	20	4	5	Бохир	Төлөвлөх шаардлагагүй

*Стандартчилал, хэмжил зүйн газрын зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яам  
1500 хувийг хэвлэв. 2014 он*

	эмчилгээ, хэт ягаан туяа/					
18	Бохир цагаан хэрэглэл, цэвэрлэгээний хэрэглэл, халдваргүйжүүлэлтийн бодис хадгалах өрөө	18	-	5	Бохир	3
19	Ариун цэврийн өрөө	20	-	1 суултуурт 50 м <sup>3</sup> /цаг, 1 шээлтүүрд 20 м <sup>3</sup> /цаг	Бохир	3
* Агаарыг цэвэршүүлж оруулах						

### Health facility room temperature and air exchange frequency requirements

№	Room type	Room temperature °C	Frequency of air exchange per 1 hour		Degree of room cleanliness	Frequency of natural ventilation
			Exhaust rate	Supply rate		
1	Ward room for adults or children with custodians	20	80 m <sup>3</sup> /h per hospital bed 100%		Clean	2
2	Tuberculosis patient ward room	20	80 m <sup>3</sup> /h per hospital bed		Not clean	2
			80%	100%		
3	Ward room for patients with hypothyroidism	24	80 m <sup>3</sup> /h per hospital bed 100%		Clean	2
4	Ward room for patients with thyrotoxicosis	15	80 m <sup>3</sup> /h per hospital bed 100%		Clean	2
5	Operation theatre, post-surgery, intensive care unit, delivery room, therapeutic pressure chamber, ward room for 1-2 patients with burns	22	According to estimation, but no less than 10 times		Clean	NA
6	Post-delivery room	22	100%*	100%	Clean	NA
7	Ward room for pediatric patients or 2-4 patients with burns	22	100%	100%	Clean	NA
8	Ward room for newborns, premature infants, breastfed children and children with injuries	25	According to estimation		Clean	NA
			100%*	80%		
			100%*	100%		
9	Full and semi-isolation rooms, pre-isolation rooms	22	2.5 (air from corridor 100%)	2.5	Not clean	2.5
10	Communicable disease ward rooms	20	80 m <sup>3</sup> /h per hospital bed 100%		Not clean	-
11	Pre-delivery, admission, examination, dressing, manipulation, pre-surgery and infant rooms	22	2	2	Clean	2
12	Sterilization rooms	18	-	3	Not clean Clean	2
13	Minor surgical procedure rooms	22	10	5	Clean	1
14	Staff room	20	From corridor	1	Clean	1
15	Functional diagnostic room	22	-	3	Not clean	2
16	Physical treatment room	20	2	3	Not clean	2
17	Physical treatment (radiation treatment, radiotherapy, ultraviolet radiation) room	20	4	5	Not clean	NA
18	Storage room for used bedding, cleaning	18	-	5	Not clean	3



№	Room type	Room temperature °C	Frequency of air exchange per 1 hour		Degree of room cleanliness	Frequency of natural ventilation
			Exhaust rate	Supply rate		
	materials and disinfection substance					
19	Restrooms	20	-	50 m <sup>3</sup> /h per flush toilet, 20 m <sup>3</sup> /h per urinal	Not clean	3
*In-flowing air shall be filtered						

**4.4.3** Бусад өрөө тасалгааны температур, агаар солилцооны давтамжийг холбогдох барилгын норм ба дүрмийн дагуу төлөвлөнө.

**4.4.4** Мэс засал, мэс заслын дараах, мэдээгүйжүүлэлт, төрөх, сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ, түлэгдэлтийн өрөө, дутуу нярай хүүхдийн тасаг, барокамерын танхим, лабораторийн өрөөнүүдэд агаарыг цэвэрлэж, чийглэж оруулдаг иж бүрэнгааржуулалтын механик болон автомат системтэй байна. Агааржуулалтын автомат системийн шүүлтүүрийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цэвэрлэж, солино.

**4.4.5** Эмнэлгийн барилгын өрөө тасалгааны агаар сэлгэлтийг бохир агаарын урсгал цэвэр өрөөнүүдэд нэвтрэх боломжгүй байхаар төлөвлөнө.

**4.4.6** Сүрьеэ, халдвартын эмнэлгийн өвчтний хагас ба бүтэн бокс, эмчилгээний өрөө тус бүрд бохир агаар гаргах механик төхөөрөмжийг төлөвлөх ба агааржуулалтын хоолойг барилгын дээвэрт гаргана.

**4.4.7** Халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөний өрөө нь агаарын сөрөг даралттай, хаалга нь орох гарах бүрт хаагддаг байна.

**4.4.8** Тусгаарлах өрөөний хаалга онгойх үед халдвар агуулсан агаар хонгил уруу алдагдахыг багасгах зорилгоор үүдний өрөө нь эерэг даралттай байна.

**4.4.3** Temperature and air exchange frequency for other rooms shall be defined in accordance with construction norms and rules.

**4.4.4** Operation theatre, post-surgery, anesthesia, delivery, reanimation, intensive care unit rooms, ward room for patients with burns or premature infants, therapeutic pressure chamber and laboratory rooms shall be equipped with mechanical or automated ventilation system. Filters of automated ventilation systems shall be cleaned and replaced in accordance with the manufacturer's instructions.

**4.4.5** Air flow in health facilities shall be organized so that unclean air flow is prevented from entering clean rooms.

**4.4.6** Tuberculosis ward rooms, full and semi-isolation rooms and procedure rooms in communicable disease wards shall be equipped with mechanical ventilation system to remove exhaust air from the room, and ventilation pipe shall be located on the roof.

**4.4.7** Ward room for sputum positive tuberculosis patient shall have negative air pressure, and its doors shall close automatically when opened.

**4.4.8** In order to prevent infected air to enter the corridor when the isolation room door is opened, entrance area shall have positive pressure.

**4.4.9** Relative humidity and air movement speed in health facility rooms shall be planned in accordance with the requirements in Table 5.

**4.4.9** Өрөө, тасгийн агаарын харьцангуй чийглэг, агаарын хөдөлгөөний хурдын хэмжээг 5-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

**5-р хүснэгт-Агаарын харьцангуй чийглэг, хөдөлгөөний хурд**

№	Өрөөний нэр	Харьцангуй чийглэг, %	Агаарын хөдөлгөөн, м/с
1	Мэс заслын тасгийн өрөөнүүд	55-60	0,15
2	Наркоз, мэс заслын дараах, эрчимт эмчилгээний, түлэгдэлтийн тасгийн 1-2 ортой өрөө, дутуу төрсөн, нялх, нярай хүүхдийн өрөө	55-60	0,15
3	Насанд хүрэгчдийн болон хүүхдийн тасгийн өрөө	35-55	0,2

**Relative humidity and air movement speed**

№	Room type	Relative humidity, %	Air movement, m/sec
1	Surgical ward rooms	55-60	0.15
2	Anesthesia, post-surgery, intensive care unit rooms, ward room for 1-2 patients with burns, ward rooms for newborn or premature infants	55-60	0.15
3	Adult or pediatric ward rooms	35-55	0.2

**4.4.10** Мэс засал, төрөх, эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах, боолт, эмчилгээний болон бусад дээрхтэй адилтгах өрөөнүүдийн агаарт эмийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг 6-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

**4.4.10** The maximum content of drugs in the air of operational theatre, delivery room, intensive care unit, reanimation, dressing, procedure and other similar rooms shall be kept in accordance with the requirements outlined in Table 6.

**6-р хүснэгт-Эрүүл мэндийн байгууллагын өрөө тасалгааныагаар дахь аюултай эмийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, аюулын зэрэглэл**

№	Эмийн бодисын нэр	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ мг/м <sup>3</sup>	Аюулын ангилал
1	Ампициллин	0,1	II A
2	Аминазин (Диметиламинопропил-) 3-хлорфенотиазинхлоргидрат	0,3	II A
3	Бензилпенициллин	0,1	II A
4	Диэтилийн эфир	300	IV
5	Ингалан (1,1-дифтор-2,2-дихлорэтилметил эфир)	200	IV
6	Азотын дутуу исэл /хүчил төрөгчид харьцуулснаар/	5	
7	Оксациллин	0,05	IA
8	Стрептомицин	0,1	IA
9	Тетрацилин	0,1	IIA
10	Трихлорэтилен	10	
11	Фторотан (1,11-Трифтор-2-хлорбромэтан)	20	III
12	Флоримицин	0,1	IIA
13	Формальдегид	0,5	IIA
14	Хлорт этил	50	IV

**Maximum content of dangerous drugs in the air of health facility rooms and their danger grading**

№	Drug	Max allowable content mg/m <sup>3</sup>	Danger grade
1	Ampicillin	0.1	IIA
2	Aminazin (Dimethylaminopropyl-3-chlorphenothiazinchlorhydrate)	0.3	IIA
3	Benzylpenicillin	0.1	IIA
4	Diethyl ether	300	IV
5	Inhalan (1,1-difluoro-2,2-dichlorethylmethyl ether)	200	IV
6	Nitrogen monoxide	5	
7	Oxacillin	0.05	IA
8	Streptomycin	0.1	IA
9	Tetracycline	0.1	IIA
10	Trichlorethylene	10	
11	Halothane	20	III
12	Florimycin	0.1	IIA
13	Formaldehyde	0.5	IIA
14	Ethyl chloride	50	IV

**4.4.11** Эрүүл мэндийн байгууллагын өрөө тасалгааны агаар дахь нянгийн ерөнхий тоо, эмгэгтөрөгч нян, хөгц мөөгөнцрийн

**4.4.11** Acceptable number of bacteria, maximum content of pathogenic bacteria and fungi, and air pollution grading levels shall be kept in

*Стандартчилал, хэмжил зүйн газрын зөвшөөрлөөр Эрүүл мэндийн яам  
1500 хувийг хэвлэв. 2014 он*

зөвшөөрөгдөх дээд хэмжээ, агаарын accordance with the requirements outlined in бохирдолтын зэрэглэлийг 7-р хүснэгтэд Table 7. заасны дагуу төлөвлөнө.

**7-р хүснэгт-Эрүүл мэндийн байгууллагын зарим өрөөний 1м<sup>3</sup> агаарт байх нянгийн тоо, агаарын цэврийн зэрэглэл**

Агаарын бохирдолтын зэрэглэл	Өрөө, тасалгааны нэр	1м <sup>3</sup> агаар дахь нянгийн ерөнхий тоо		1м <sup>3</sup> агаар дахь стафилококк ауреусын тоо		1м <sup>3</sup> агаар дахь хөгц мөөгөнцрийн тоо	
		Ажил эхлэхийн өмнө	Ажлын үеэр	Ажил эхлэхийн өмнө	Ажлын үеэр	Ажил эхлэхийн өмнө	Ажлын үеэр
Маш цэвэр (А)	Мэс засал, төрөх өрөө, цусны ариун өрөө, дутуу нярайн өрөө, эмийн сангийн ариун өрөө, ариутгал, нян судлалын лабораторийн бокс, түлэгдсэн үйлчлүүлэгчийн өрөө	200-аас бага	500-аас бага	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй
Цэвэр (Б)	Боолтын, ажилбарын, мэс заслын өмнөх, сэхээн амьдруулах, хүүхдийн, эхийн сүүг цуглуулж, ариутгах өрөө, нян судлал, клиникийн лабораторийн өрөө	500-аас бага	750-аас бага	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй
Харьцангуй цэвэр	Мэс заслын ба халдвартын тасгийн үйлчлүүлэгчийн өрөө, хонгил, үзлэгийн, цэвэр цагаан хэрэглэлийн өрөө	750-аас бага	1000-аас бага	Илрэх ёсгүй	2-оос бага	Илрэх ёсгүй	Илрэх ёсгүй
Бохир (П)	Хонгил, захиргааны өрөө, эмчилгээ оношилгооны хэсгийн шат, ариун цэврийн өрөө, бие засах газар, бохир цагаан хэрэглэлийн өрөө	Норм тогтоохгүй		Норм тогтоохгүй		Норм тогтоохгүй	

**Bacterial content and air quality grading requirements  
for health facility rooms**

Air pollution grade	Room type	Number of bacteria per 1 m <sup>3</sup> of air		Number of <i>S. aureus</i> per 1 m <sup>3</sup> of air		Number of fungi per 1 m <sup>3</sup> of air	
		Before work shift	During work shift	Before work shift	During work shift	Before work shift	During work shift
Extremely clean (A)	Operational theatre, delivery room, sterile rooms of blood banks, rooms for premature infants, sterile rooms of pharmacies, sterilization room, bacteriological laboratory, ward rooms for patients with burns	Less than 200	Less than 500	None	None	None	None
Clean (B)	Dressing, procedure, pre-surgery, reanimation, pediatric ward room, breastmilk collection and sterilization room, bacteriological and clinical laboratory	Less than 500	Less than 750	None	None	None	None
Relatively clean	Patient rooms in surgery and communicable disease wards, corridor, examination room and storage room for clean bedding	Less than 750	Less than 1000	None	Less than 2	None	None
Polluted (P)	Corridor, administration rooms, staircases, sanitary amenities, storage room for used bedding	No norm		No norm		No norm	

## 4.5 Гэрэлтүүлэг

**4.5.1** Эрүүл мэндийн байгууллага нь цахилгааны нөөц үүсгүүртэй байна.

**4.5.2** Эмчилгээ, үйлчилгээний үндсэн өрөө, хонгил нь байгалийн болон зохиомол гэрэлтүүлгээр хангагдсан байх ба эрүүл ахуйн шаардлага хангасан (флуорисценци ламп)гэрэлтүүлэг ашиглана.

**4.5.3** Хэвтүүлэн эмчлэх тасагт шөнийн цагаар эмчилгээ, үйлчилгээ явуулахад бусадэмчлүүлэгчдэд сөрөг нөлөө үзүүлэхгүй нөхцлийг бүрдүүлэн, ханын болон зөөврийнгэрэлтүүлэгтэй байна.

**4.5.4** Мэс заслын өрөө 1500-аас 3000 люкс, мэс ажилбарын талбай 3000-аас 6000 люксэмчлүүлэгчийн өрөө 60 люкс, үзлэгийн өрөө 100 люкс бүхий хэт халалтаас сэргийлсэн(флуорисценци ламп)гэрэлтүүлэгтэй байна.

**4.5.5** Цогцос хадгалах болон үдэх ёслолын өрөө нь ханын 30-40 ваттын гэрэлтүүлэгтэй байна. Эмнэлэгээс эмгэг судлалын хэсэг руу явах замд гэрэлтүүлэгтэй байна.

**4.5.6** Эрүүл мэндийн байгууллагын зарим өрөө, тасалгааны байгалийн гэрэлтүүлгийг 8-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө

## 4.5 Hospital lighting requirements

**4.5.1** Health facilities shall have alternate power supply source.

**4.5.2** Treatment and care rooms and corridors shall have natural and artificial lighting. Artificial lighting (fluorescent lamps) shall comply with respective hygienic requirements.

**4.5.3** Hospital wards shall have bedside and portable lighting for the purposes of providing treatment and care during nighttime with the minimal disturbance to other patients.

**4.5.4** Lighting of operating room, operating table, hospital ward and examination room shall be 1500-3000, 3000-6000, 60 and 100 lux, respectively. Overheating proof (fluorescent) lamps shall be used.

**4.5.5** Mortuary shall have wall-mounted 30-40 Watt lighting. Route from hospital to pathology unit shall be properly lit.

**4.5.6** Natural lighting of health facility rooms shall be planned in accordance with the requirements shown in Table 8.

**8-р хүснэгт-Байгалийн гэрэлтүүлгийн төлөвлөлт**

Өрөөний нэр	Цонх байрлах зүг чиг	
	Хамгийн тохиромжтой	Зөвшөөрөгдөх
Мэс засал, сэхээн амьдруулах, төрөх, тусгаарлах өрөө	Х, ЗХ, БХ,	З
Нян судлал, халдвартай материал хүлээн авах, задлан шинжилгээний өрөө	Х, ЗХ, БХ, ЗУ, З	У
Сүрьеэ болон бусад халдвартай өрөө	У, ЗУ, З, ЗХ, БХ	ЗХ
Хүүхдийн өрөө, эрчимт эмчилгээний өрөө, тоглоомын өрөө	Баруун зүгт чиглэсэн цонхтой байж болохгүй, эрчимт эмчилгээний өрөөний цонх баруун буюу баруун өмнөд зүг руу чиглэсэн байж болохгүй	
ТАЙЛБАР: Х -хойд, З –зүүн, У-урд, ЗХ- зүүн хойд, БХ – баруун хойд, ЗУ- зүүн урд		

## Natural lighting requirements

Room type	Direction windows shall face	
	Most desirable	Acceptable
Surgery, reanimation, delivery and isolation rooms	N, NE, NW	E
Bacteriology, reception for infected materials, forensic examination room	N, NE, NW, SE, E	S
Tuberculosis and other communicable disease ward rooms	S, SE, E, NE, NW	NE
Pediatric rooms, intensive care unit, indoor playgrounds	Shall not face West; intensive care unit rooms shall not face West or South-West	
<i>Note: N – North, E – East, S – South, W - West</i>		

### 4.6 Дуу шуугиан

**4.6.1** Эрүүл мэндийн байгууллагын орчинд байх дуу шуугианы норм хэмжээг р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө

### 4.6 Noise requirements

**4.6.1** Environmental noise levels around health facility shall comply with the norms shown in Table 9.

### 9-р хүснэгт-Дуу шуугианы норм хэмжээ

№	Өрөө тасалгааны нэр	Дууны түвшин, дБ(А)
1	Үйлчлүүлэгч, мэс заслын, мэс заслын хагалгааны өрөөнд: -Өдөр -Шөнө	35-аас ихгүй 30
2	Үзлэгийн өрөө	40

### Noise norms

№	Room type	Noise level, dB(A)
1	Operational theatre, post-surgery and other ward rooms: - During daytime - At night	Not more than 35 30
2	Examination room	40

### 5 Усны чанар, аюулгүй байдал

**5.1** Эрүүл мэндийн байгууллага нь төвлөрсөн болон хэсгийн ус хангамжийн системд холбогдсон байна.

**5.2** Эрүүл мэндийн байгууллагад хэрэглэх унд, ахуйн ус нь стандартын шаардлага хангасан байна.

**5.3** Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, бүсийн дэглэмийг мөрдөж ажиллана.

### 5 Water quality and safety

**5.1** Health facility shall be connected to centralized or local water supply system.

**5.2** Drinking and domestic water in health facilities shall comply with the requirements of relevant standards.

**5.3** Drinking water sources shall have hygienic protection area established, and protection regimen shall be followed.

**5.4** Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйчилгээнд хэрэглэх усны хамгийн бага хэмжээ нь 10-р хүснэгтэд заасны дагуу төлөвлөнө.

**5.4** Minimum water use requirements in health facilities shall comply with the requirements shown in Table 10.

**10-р хүснэгт-Эрүүл мэндийн байгууллагад шаардагдах усны хамгийн бага хэмжээ**

Усны зориулалт	Шаардагдах усны хамгийн бага хэмжээ
Амбулаториор үзүүлэх	5 литр/үзлэг
Хэвтэн эмчлүүлэгч	40-60 литр/өвчтөн/хоног
Мэс засал, төрөх тасаг	100 литр/ажилбар
Хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний хоолны газар	30 литр/өвчтөн/хоног
Холерын эмчилгээний төв	60 литр/ өвчтөн/хоног
Амьсгалын замын цочмог өвчний тусгаарлах төв	100 литр/ өвчтөн/хоног
Вируст цусархаг чичрэг	300-400 литр/өвчтөн/хоног

**Minimum water use requirements in health facilities**

Water use category	Minimum water requirement
Outpatient examination	5 L/examination
Inpatient case	40-60 L/patient/day
Surgery and delivery ward	100 L/procedure
Kitchen for inpatients	30 L/patient/day
Cholera treatment unit	60 L/patient/day
Isolation room for acute respiratory cases	100 L/patient/day
Viral hemorrhagic fever unit	300-400 L/patient/day

**5.5** Эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэх ус болон ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж, гар угаагуур зэрэг нь үйлчлүүлэгчдэд ойр, хангалттай тоогоор байна.

**5.5** Water, water purification equipment and sinks shall be easily accessible for patients and in sufficient numbers.

**5.6** Мэс засал, төрөх, эрчимт эмчилгээ эдгээртэй адилтгах тасаг, нэгжид мэдрэгч бүхий угаалтуур байхаар төлөвлөнө.

**5.6** Surgery, delivery, intensive care unit and similar wards shall be equipped with washbasins with sensors.

**5.7** Ус хангамжийн төвлөрсөн системд холбогдоогүй тохиолдолд гар угаах нөхцлөөр хангасан байна.

**5.7** Amenities for hand washing shall be provided in case health facility is not connected to the centralized water supply system.

## **6 Шингэн хог хаягдлын зайлуулалт**

## **6 Liquid waste management**

**6.1** Эрүүл мэндийн байгууллага нь бохир ус зайлуулах төвлөрсөн системд холбогдсон байна.

**6.1** Health facility shall be connected to centralized sewage system.

**6.2** Төвлөрсөн системд холбогдоогүй нөхцөлд шаардлага хангасан хэсгийн цэвэрлэх байгууламж болон цооногтой байхаар төлөвлөнө. Цооногт цуглуулсан бохир усыг халдваргүйжүүлсний дараа зориулалтын

**6.2** Health facility shall have proper local liquid waste treatment system or pit in case it is not connected to centralized sewage system. Sewage in the pit shall be disinfected and transported to a



тээврийн хэрэгслэлээр тээвэрлэж тогтоосон цэгт зайлуулна.

**6.3** Халдвартын эмнэлгийн бохир усыг урьдчилан халдваргүйжүүлэлт хийж ариутгах татуургын төвлөрсөн системд нийлүүлнэ.

**6.4.** Бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах ус нь холбогдох стандартад заасан шаардлагыг хангасан байна.

**6.5** Хүнд өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, жирэмсэн, өндөр настай хүмүүст бие засах газар нь хэрэглэхэд хялбар дөхөм, хүүхэд унаж, гэмтэж бэртэхээс хамгаалсан, тохирсон хэмжээ загвартай байна.

**6.6** Төвлөрсөн системд холбогдох боломжгүй тохиолдолд бие засах газрыг хөрс, гүний ус бохирдуулахгүй, үерийн усанд автагдахгүй байхаар стандартын дагуу байгуулж ашиглана.

**6.7** Бие засах газар нь 30 метрээс холгүй зайд гэрэлтүүлэгтэй, хүрч очих замыг тэгшилж зассан, эрүүл ахуйн хувьд цэвэрхэн, аюулгүй, хэрэглэхэд хялбар хийгдэнэ.

designated treatment plant using proper transportation.

**6.3** Sewage from communicable disease hospital shall be disinfected before being released into the centralized sewage system.

**6.4** Water released from sewage treatment plant shall comply with the requirements of relevant standards.

**6.5** Latrine for the severely ill, the disabled, the elderly and pregnant women shall be convenient to use, designed to prevent falls, and have proper size dimensions.

**6.6** In case health facility is not connected to centralized sewage system, latrines shall be located so as to prevent soil and deep water contamination, and damage from flooding.

**6.7** Outdoor sanitary amenities shall be located not more than 30 meters away from the health facility building, have proper lighting and paved path, and be maintained in clean and safe condition.

## **7 Угаалга, цэвэрлэгээ**

### **7.1 Цэвэрлэгээ**

**7.1.1** Эрүүл мэндийн байгууллагад хийх цэвэрлэгээг тасаг, нэгжийн үйл ажиллагаа, халдварын эрсдэлээс хамааруулан 3 бүсэд хуваана. Үүнд:

- Энгийн буюу С бүс
- Дунд эрсдэлтэй буюу В бүс
- Өндөр эрсдэлтэй буюу А бүс

**7.1.2** Энгийн буюу С бүсэд - захиргаа, хонгил, сургалтын болон ажилчдын амрах өрөө, агуулах зэрэг хамаарах бөгөөд цэвэрлэгээг угаалгын бодистой ус ашиглан өдөр бүр хийнэ.

**7.1.3** Дунд эрсдэлтэй буюу В бүсэд– Хүлээн авах, хүлээлийн өрөө, амбулатори, оношзүйн хэсэг, үзлэгийн өрөө, халдварт бус өвчний тасаг, эмч, сувилагчийн өрөө, сахиур болон ар гэрийнхний байрлах өрөө, нөхөн сэргээх эмчилгээний хэсэг, эмийн сан, гал тогоо, угаалга зэрэг хамаарах бөгөөд угаалгын болон халдваргүйтгэлийн бодис ашиглан цэвэрлэгээг өдөрт 2-оос доошгүй удаа болон бохирдсон тухай бүрд хийнэ.

## **7 Laundry and cleaning**

### **7.1 Cleaning**

**7.1.1** For cleaning purposes departments and units of the health facility shall be divided into the following three zones:

- Low risk zone or C zone
- Medium risk zone or B zone
- High risk zone or A zone

**7.1.2** Low risk or C zone includes administration offices, corridor, storage rooms, training facilities and staff rest area, and shall be cleaned daily with detergent solution.

**7.1.3** Medium risk or B zone includes reception, waiting hall, outpatient clinic, diagnostic cabinets, examination rooms, non-communicable disease inpatient wards, staff offices, rooms for patient custodians, rehabilitation treatment cabinets, pharmacy, kitchen and laundry, and shall be cleaned at least twice daily (or as required when soiled) with detergent and disinfectant solutions.

**7.1.4** High risk or A zone includes operational theatre, dressing and procedure rooms, departments of endoscopy, obstetrics, newborn

**7.1.4** Өндөр эрсдэлтэй буюу А бүсэд–Мэс заслын өрөө, боолтын болон ажилбарын өрөө, дуран, төрөх, нярай, хүүхэд, эрчимт эмчилгээний тасаг, гемодиализ, яаралтай тусламжийн хэсэг, хүнд өвчтөний болон халдварт өвчтөний тасаг, эм найруулах, лаборатори, төвлөрсөн ариутгалын хэсэг, угаалгын бохир хүлээн авах хэсэг, хог хаягдал цуглуулах байр, ариун цэврийн өрөө хамаарах бөгөөд өдөрт 3-аас доошгүй удаа бохирдсон даруйд угаалга, халдваргүйтгэлийн бодистой уусмалаар цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг өндөр үр дүнтэй хийнэ.

**7.1.5** Цэвэрлэгээ хийхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална. Үүнд:

- өдөр тутмын буюу байнгын цэвэрлэгээг тухайн тасаг нэгжийн ажил үйлчилгээнээс хамаарч хийнэ. Их цэвэрлэгээг 14 хоногт нэг удаа хийх;
- их цэвэрлэгээг бүх гадаргуу /хана, тааз, шал/, хаалга, цонх, шат, хаалганы бариул, шугам хоолой болон тавилга хэрэгсэл, эмчилгээ үйлчилгээнд хэрэглэж буй бүх тоног төхөөрөмжийг хамруулан хийх;
- биологийн шингэн /цус, бөөлжис, ялгадас/ асарсан тохиолдолд халдваргүйтгэлийн бодисоор цэвэрлэж халдваргүйтгэх;
- хэвтэн эмчлүүлэгчийн ор, шүүгээг өвчтөн эмнэлгээс гарсан даруйд заавал халдваргүйтгэж цэвэрлэх;
- тавилга, хана, шал, тосгуур, суултуурын алчуур, хувинг өнгөөр ялган тэмдэглэж, хооронд нь дамжуулан хэрэглэхгүй байх;
- цэвэрлэгээнд хэрэглэх халдваргүйтгэлийн бодисыг зааврын дагуу бэлтгэж, хадгалж, хэрэглэх;
- эмнэлгийн үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийн нягтралыг харгалзан цэвэрлэгээ хийх хуваарийг тухайн байгууллагын дотоод журмаар зохицуулах;
- өрөө, тасалгаанд цэвэрлэгээ хийх явцдаа үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр ор болон бусад эд зүйлд нь хүрэх, сууж амрах, чимээ шуугиан гаргах зэргээр тэдэнд саад болохгүй байх;
- үйлчлэгч нар цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэгээг тусгай хяналтын хуудсан дээр тэмдэглэж хананд байрлуулна.

and pediatric care, and hemodialysis, intensive care unit, ER, communicable disease wards, pharmaceutical preparation room, laboratory, centralized sterilization unit, reception area for used laundry, waste collection room and sanitary amenities, and shall be cleaned at least 3 times daily (or as required when soiled) with detergent and disinfectant solutions.

**7.1.5** The following principles shall be adhered to during cleaning:

- Daily cleaning shall be scheduled taking into account the department or unit's operation schedule. General cleaning shall be done every 14 days.
- General cleaning shall involve cleaning of all surfaces (walls, ceiling, floors), doors, windows, stairs, door knobs, pipes, furniture and equipment used in treatment and care.
- In case of spill of biological liquids (blood, vomit, urine etc.) disinfectants shall be used for disinfection and cleaning.
- Hospital beds and bedside furniture shall be disinfected and cleaned immediately after the patient discharge.
- There shall be separate towels and buckets for cleaning furniture, walls, floor, washbasins and septic tanks, which shall be color-coded to prevent mixing.
- Disinfectants for cleaning shall be prepared, stored and used in accordance with the instructions.
- Cleaning shall be scheduled in accordance with the health facility by-laws taking into account the facility's operation schedule and patient load.
- Service personnel are prohibited from touching patient bed or belongings without permission, taking break in patient rooms or making excess sound while cleaning.
- Service personnel shall sign cleaning checklists placed in visible areas,

## **7.2 Угаалга**

**7.2.1** Эмнэлгийн орны тоо, хүчин чадлаас хамааран зөөлөн эдлэл болон эмч, ажилчдын хувцсыг угаах нэгдсэн угаалгын тасаг, хэсэгтэй байна.

**7.2.2** Угаалгын тасаг, хэсэг нь шаардлагатай хүний нөөц, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, өрөө тасалгаагаар хангагдсан байна.

**7.2.3** Эмнэлгийн зөөлөн эдлэл, эмч, ажилчдын хувцсыг нэгдсэн угаалгын тасгаас бусад газар буюу эмчилгээ, үйлчилгээний тасагт болон гадагш авч гарч угаахыг хориглоно.

## **7.3 Үйлчилгээний ажилчдад тавих шаардлага**

**7.3.1** Үйлчилгээний ажилчид халдвартай материал, хурц үзүүр, ирмэгтэй зүйлд өртөх эрсдэлтэй тул халдвараас сэргийлэх, халдварт өртөхгүй байх журмыг мөрдлөг болгон ажиллана.

**7.3.2** Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд зохих журмын дагуу жилд 2 удаа хамрагдаж, байнгын халдвар тээгчээр илэрвэл хөдөлмөр зохицуулалт хийнэ.

**7.3.3** Ажил, үйлчилгээ эхлэхийн өмнө ажлын хувцас /өмд цамц, гутал, малгай, маск, бээлий зэрэг/ өмсөнө.

**7.3.4** Ажлын хувцсыг гадагш авч явах, ажлын хувцастай эмнэлгийн гадна орчин болон нийтийн үйлчилгээний газраар явахыг хориглоно.

**7.3.5** Цэвэрлэгээ хооронд болон ажлын дараа гараа зөв угааж хэвшсэн байх ба ажлын төгсгөлд шүршүүрт орно.

**7.3.6** Цэвэрлэгээний явцад ажил дуусаагүй байхад амрах, халдваргүйтгэл хийлгүйбээлий тайлж өөр ажил хийх, юм идэж уух, ажлын байрыг орхихыг хориглоно.

**7.3.7** Аливаа өртөлт, эрсдэл болон халдварт өвчнөөр өвдсөн тохиолдолд халдвар хяналтын ажилтан, нэгжийн дарга болон тархвар судлаач эмчид мэдээлнэ.

**7.3.8** Биеийн ил хэсэгт ил шарх, шалбархайтай үед цэвэрлэгээ, угаалга хийж болохгүй.

## **7.2 Laundry**

**7.2.1** Health facility shall have centralized department or unit for laundry of soft furnishings and staff uniform depending on the number of hospital beds and service capacity.

**7.2.2** Laundry department or unit shall have necessary human resources, supplies, equipment and physical facilities.

**7.2.3** Laundry of soft furnishings and staff uniform is prohibited in areas other than the laundry department or unit, such as other departments, wards or other places.

## **7.3 Requirements for cleaning service staff**

**7.3.1** Service staff shall follow approved infection prevention and control regulations as they are at risk of being exposed to infected materials and sharps.

**7.3.2** Staff shall have prophylactic examinations and testing semi-annually in accordance with the relevant regulations, and shall be transferred to appropriate position in case of chronic carrier status.

**7.3.3** Staff shall put on protective work clothing (pants, jacket, footwear, cap, face mask and gloves) before starting the cleaning work.

**7.3.4** Protective work clothing shall not be carried out of the health facility, and staff is prohibited from wearing the work clothing outside the health facility.

**7.3.5** Staff shall properly wash their hands after cleaning, and shall take shower at the end of the working day.

**7.3.6** Staff is prohibited from taking break, eating or leaving the duty station during the cleaning before the work is completed, or taking off the gloves without disinfection.

**7.3.7** Infection control staff, head of the unit and epidemiologist shall be notified in case of infection exposure or manifest communicable disease.

**7.3.8** Staff is prohibited from engaging in cleaning services in case of open wound or ulceration in exposed body parts.

## 8 Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал

### 8.1 Ерөнхий шаардлага

**8.1.1** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр нь зориулалтын, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр бүрэн хангагдсан, технологи урсгалын дагуу зөв зохион байгуулагдсан, шавж мэрэгч нэвтрэхээс хамгаалагдсан байна.

**8.1.2** Үйлдвэрлэлийн хэсгийн хана, тааз, шалыг угааж цэвэрлэхэд хялбар материалаар хийж, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж, автомат агааржуулалтын системийг байрлуулсан байна.

**8.1.3** Гал тогоо нь хүнсний төрөлжсөн /түүхий бүтээгдэхүүн, хуурай хүнс, махны/ агуулахтай байна.

**8.1.4** Үйлдвэрлэлийн хэсэг нь хоолны газрын ариун цэврийн дүрмийг баримталж, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан хоолоор үйлчилнэ.

**8.1.5** Мэргэжлийн тогооч, хоол үйлдвэрлэлийн технологич, хоол зүйч, эрүүл ахуйч зэрэг боловсон хүчнээр хангагдсан байна.

**8.1.6** Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг гардан боловсруулдаг, үйлдвэрлэдэг, тээвэрлэдэг, худалддаг буюу түүгээр үйлчилгээ үзүүлдэг, хүнсний бүтээгдэхүүн болон хүнсний сүлжээнд ашиглах, хэрэглэх эд зүйлстэй биечлэн харьцдаг ажилтан, ажиллагсад нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байна.

**8.1.7** Хоол хүнс бэлтгэхэд хэрэглэх ундны ус нь холбогдох стандартын шаардлага хангасан байна.

**8.1.8** Эмчилгээ, сувиллын хоолыг батлагдсан удирдамж, журам, технологийн зааврын дагуу хийж, өдөрт 3-аас доошгүй удаа хоолоор үйлчилнэ.

**8.1.9** Сахиурт зориулсан хоолны өрөө нь тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав суулгаар хангагдсан байна.

**8.1.10** Хоол үйлдвэрлэлийн хэсгээс хоолыг зөөвөрлөхдөө хөрч, бохирдохоос сэргийлэн эрүүл ахуйн шаардлага хангасан, зориулалтын саванд хийж, тэргэнцэр болон

## 8 Food hygiene and safety

### 8.1 General requirements

**8.1.1** Kitchen shall be equipped with necessary appliances and supplies, protected from insects and rodents, and have appropriate technologic flow.

**8.1.2** Kitchen walls, floor and ceiling shall be made of easy to clean materials, occupational safety requirements shall be followed, and properly functioning automated air conditioning system shall be installed.

**8.1.3** Kitchen shall have separate storage rooms for raw materials, dry food and meat.

**8.1.4** Kitchen safety and hygiene rules shall be followed, and safe food shall be served.

**8.1.5** Kitchen shall be staffed with professional cook, food manufacturing technologist, diet specialist and hygienist.

**8.1.6** Staff involved in processing, manufacturing, transportation and distribution of food raw materials and food products, as well as staff working with appliances used in food chain shall undergo preventive health examination and testing.

**8.1.7** Drinking water used in cooking shall comply with the requirements of relevant standards.

**8.1.8** Treatment meals shall be prepared in compliance with approved guidelines, regulations and technological instructions, and shall be served at least 3 times daily.

**8.1.9** Kitchen facilities for patient custodians shall have necessary equipment, appliances and supplies.

**8.1.10** Food from kitchen shall be transported in proper containers complying with hygienic requirements using wheel-trays and designated elevators in order to prevent contamination and cooling.

**8.1.11** Cloakrooms, shower and sanitary amenities for kitchen staff shall be provided.

хүнсний зориулалттай цахилгаан шатаар зөөвөрлөнө.

**8.1.11** Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан, ажиллагсад зориулсан хувцас солих өрөө, угаалтуур, шүршүүр, бие засах газартай байна.

## **8.2 Дотоод хяналт**

**8.2.1** Хоол үйлдвэрлэлд оролцох ажилтан нь 2-3 ээлжийн ажлын хувцастай, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горим мөрдөж ажиллана.

**8.2.2** Хүнстэй шууд болон шууд бусаар харьцдаг ажилтныг ажлаа эхлэх, гараа бохирдсон тухай бүрт гараа угаах нөхцлийг бүрдүүлсэн байна.

**8.2.3** Хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажилтан, ажиллагсад ил шарх үүссэн, хамар, нүд, чихнээс идээт шүүрэл гарах зэрэг шинж тэмдэг илэрсэн, суулгаж, бөөлжсөн тохиолдолд хоол хүнстэй ажиллуулахгүй байна.

**8.2.4** Эмчилгээний хоолыг үйлдвэрлэсэн тухай бүр дээж авч зориулалтын хөргөгчинд 48 цаг хадгалж, дээжийг авсан, устгасан тэмдэглэлийг хөтлөнө.

## **9 Хог хаягдал**

**9.1** Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад зохих журмыг мөрдөж ажиллана.

## **10 Шавьж мэрэгчээр дамжих өвчний хяналт**

**10.1** Эрүүл мэндийн байгууллага нь тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг жилд 2-оос доошгүй удаа, шавж, мэрэгчийн тархалт ихэссэн тохиолдолд тухай бүр устгал хийлгэнэ.

**10.2** Мэргэжлийн байгууллагаар шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийг улсын бүртгэлд бүртгэгдсэн, аюулгүй ажиллагааны зааварчилгаа батлагдсан хор бодисоор устгал хийлгэнэ.

**10.3** Эрүүл мэндийн байгууллагад үүрлэсэн шавж, мэрэгчийн төрөл зүйл, байрлал

## **8.2 Internal inspection**

**8.2.1** Kitchen staff shall have 2-3 sets of protective work clothing, and shall follow occupational safety rules and regulations.

**8.2.2** Staff in direct or indirect contact with food shall be provided with facilities to wash their hands before starting work and in cases of contamination.

**8.2.3** Kitchen staff are prohibited from getting in contact with food in cases of open wound, abnormal secretions from nose, eyes or ears, diarrhea or vomiting.

**8.2.4** Samples from prepared food shall be taken immediately upon preparation, kept in refrigerator for 48 hours, and a registry of sample taking and destruction shall be maintained.

## **9 Waste management**

**9.1** Health facility waste shall be sorted out, collected, stored, transported, disinfected and disposed in accordance with the relevant regulations.

## **10 Control of vector-borne diseases**

**10.1** Health facility shall contract a licensed professional agency to carry out pest control and deratization at least twice annually or as required in cases of increased distribution of insects or rodents.

**10.2** Pest control and deratization shall be performed by a professional agency using officially registered toxic substances in compliance with the safety instructions.

**10.3** Species, location (distribution), number and resistance to chemicals of insects and rodents in the health facility shall be monitored, and the

/тархалтын түвшин/, тоошил, химийн бодист тэсвэртэй байдал зэрэгт үнэлгээ хийж, шавьжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн үр дүнд хяналт тавьж ажиллана.

**10.4** Барилга нь шавж, мэрэгч болон бусад амьтан нэвтрэхээс хамгаалагдсан, ан цавгүй, нүх цоорхойгүй байна.

**10.5** Хонгил, агуулах, хог хаягдлын цэг, агааржуулалтын хоолой болон бусад газруудад шавж, мэрэгч үүрлэхээс сэргийлж цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг зохих журмын дагуу хийнэ.

**10.6** Дулааны улиралд шумуул, ялаа орохоос сэргийлж цонхны онгойх хэсгийг тороор бүрхсэн байна.

**10.7** Шавж, мэрэгчээр дамжин тархах халдвараас сэргийлэх талаар сургалт, сургалчилгааг зохион байгуулна.

## **11 Эрүүл ахуйг дэмжих, сургалт мэдээллийн үйл ажиллагаа**

**11.1** Халдвараас сэргийлэх, хянах сургалт нь эрүүл мэндийн байгууллагын ажилтан, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн байна.

**11.2** Эрүүл мэндийн байгууллага нь эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх сургалтын батлагдсан удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна. Давтан болон тасралтгүй сургалтыг зохион байгуулахаар төлөвлөнө.

**11.3** Сургалтыг эмч, эмнэлгийн ажилтан болон үйлчлүүлэгчдэд гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулна.

**11.4** Шинээр ажилд орж буй эмч, эмнэлгийн ажилтан болон дадлага хийж буй оюутнуудыг халдвараас сэргийлэх сургалтанд хамруулна.

**11.5** Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчдэд халдвараас сэргийлэх талаарх мэдээлэл, сургалтыг тогтмол хийж, үзүүлэн таниулах материал, мэдээллийн самбар, видео, зурагт хуудсыг ашиглана.

effectiveness of pest control and deratization shall be assessed.

**10.4** Health facility building shall be protected from insects and rodents, and shall have no holes or cracks.

**10.5** Corridors, storage rooms, waste disposal areas, ventilation pipes and other similar areas shall be cleaned and disinfected according to guidelines in order to prevent insects or rodents from lurking.

**10.6** Windows shall have screens to prevent mosquitoes and flies from entering inside the health facility.

**10.7** IEC activities to prevent from vector-borne infections shall be conducted.

## **11 Training and education on hygiene**

**11.1** Training on infection prevention and control shall aim at ensuring health staff and client safety.

**11.2** Health facility shall have approved guidelines, curriculum and plan of training on prevention of hospital-borne infections. Refresher and continuous trainings shall be planned.

**11.3** Training shall be conducted separately for health staff and clients.

**11.4** Newly recruited health staff and interns shall undergo infection prevention and control training.

**11.5** Health facility shall organize regular IEC on infection prevention for clients using visual aids, information boards, videos and posters.

## **ТӨГСӨВ**